



**ХАРИЛЦАА ХОЛБООНЫ  
ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
ТОГТООЛ**

2025 оны 02 сарын 03 өдөр

Дугаар 20

Улаанбаатар хот

Сүлжээний дугаарын ашиглалтад  
өөрчлөлт оруулах тухай

Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.9 дэх заалт, Харилцаа холбооны зохицуулах хорооны 2021 оны 74 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан “Харилцаа холбооны сүлжээний дугаарын ашиглалт, үйлчилгээг бүртгэхтэй холбогдсон журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.4, 4 дүгээр зүйлийн 4.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Жимобайл нэт ХХК-д олгосон харилцаа холбооны сүлжээний дугаарлалтын багцаас “780х-xxxx” дугаарлалт бүхий нийт 100,000 /нэг зуун мянга/ дугаарыг буцаан авч, дугаарын ашиглалтад өөрчлөлт оруулсугай.
2. Сүлжээний дугаарын ашиглалтад өөрчлөлт оруулсантай холбогдуулан тус компаниас ирүүлсэн хүсэлтийн дагуу “780х-xxxx” дугаарлалт бүхий 100,000 /нэг зуун мянга/ дугаарын зохицуулалтын үйлчилгээний хөлсийг 2024 оны 12 дугаар сарын 13-ны өдрөөр тасалбар болгон тооцохыг Захиргааны удирдлага, хамтын ажиллагааны газар /З.Эрдэнэчулуун/-т үүрэг болгосугай.
3. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан Жимобайл нэт ХХК-тай байгуулсан сүлжээний дугаарлалтын гэрээнд холбогдох өөрчлөлтийг тусган, гэрээг шинэчлэн байгуулахыг тус Хорооны дарга /Г.Чинзориг/-д үүрэг болгосугай.

ДАРГА

ГИШҮҮД



Г.ЧИНЗОРИГ

Б.АНХБААТАР

Б.БАТЗОРИГ

Ч.ЗОЛБАЯР

А.ЛУВСАН-ОЧИР

Н.МАНДАХБААТАР

А.ҮЙЛСТӨГӨЛДӨР